



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2017 оны 10 дугаар сарын 16

№ 01/74

Мандалговь хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэн Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2015-2016 онд ИТХ-ын ажлын албаны ажилчдын албан томилолт, 4 жилийн үйл ажиллагааны тайланг хэвлүүлэх, аймгийн Засаг даргын хэрэгжүүлсэн “Иргэний оролцоо-Хөгжлийн бодлого” сэдэвт бага хурлын хоолны төлбөр зэрэг ИТХ-ын ажлын албаны зардалд 10,222,500 /Арван сая хоёр зуун хорин хоёр мянга таван зуун/ төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.4-д /Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно;/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д/ Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн

0000000102

зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/, 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/, гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоож, нягтлан бодогч Д.Сольхүү нарт хариуцуулав.

 <p>ӨГСӨН¹: АУДИТОР <i>[Signature]</i> Д.ДОЛЖИНСҮРЭН 4817144213 ЗЮА0039 9033475</p>	<p>АЛБАН ШААРДЛАГЫГ</p>	 <p>ЗӨВШӨӨРСӨН: ДАРГА <i>[Signature]</i> Ц.МӨНГӨНЦООЖ НЯГТЛАН БОДОГЧ <i>[Signature]</i> Д.СОЛЬХҮҮ ЗКА0007 9034013</p>
--	--------------------------------	--

¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүднэ/